



## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.12.23 - 12.27

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Зул сарын баярын амралтын өдрүүдтэй холбоотой арилжааны өдөр цөөхөн байсан өнгөрөгч долоо хоногт хөрөнгө оруулагчдод худалдааны хэлэлцээрт эерэг хүлээлттэй байгаагаас үүдэн АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа.

Технологийн компаниудын илүүтэйгээр агуулдаг Nasdaq индекс 9,000 нэгжийг түүхэнд анх удаа давлаа. S&P 500 индексийн сагсанд багтах өргөн хэрэглээний бус бараа бүтээгдэхүүний салбарын зах зээлийн үнэлгээний 25 орчим хувийг бүрдүүлдэг Amazon компанийн хувьцааны ханшийн өсөлтөөс үүдэн өргөн хэрэглээний бус бараа бүтээгдэхүүний салбар хамгийн өндөр өсөлтийг үзүүлээ. Жижиглэнгийн худалдаа болон интернет үйлчилгээ үзүүлэгч компаниудын хувьцаа баярын өдрүүдийн борлуулалт их байсантай холбоотой мөн өссөн бол ус, цахилгаан, дулааны салбар бууралттай байлаа.

Эдийн засгийн үзүүлэлтүүд өсөлт султай байгаатай холбоотойгоор 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж буурлаа. Хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй компанийн бондын өгөөж болон засгийн газрын үнэт цаасны өгөөжийн зөрүү буурсаар байна.

**Европ:** Баярын өдрүүдтэй холбоотой арилжаа бага явагдсан өнгөрөгч долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд бага хэмжээний өсөлт үзүүлсэн ч түүхэн ханшуудад хүрлээ.

Хэдийгээр Европын зах зээлтэй холбоотой мэдээллүүд ховор байсан ч шинжээчид АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүдийн өсөлт, АНУ болон БНХАУ-ын хоорондын эхний шатны худалдааны хэлэлцээр Европын хөрөнгийн зах зээлийн индексүүдэд эерэгээр нөлөөлсөн гэж үзэж байна.

Итали улсын Парламент 2020 оны төсвийг баталлаа. Итали улсын эрх баригч нам худалдааны татварыг нэмэгдүүлэх шийдвэрийг өрхийн хэрэглээ буурах хадлагатай байгаатай холбоотой цуцалсан ба төсвийн зорилтот алдагдлыг 3 дахь жилдээ ДНБ-ын 2.2% байлгах аар тогтоожээ.

**Япон:** Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд хөдөлгөөн багатайгаар хаагдлаа.

Bloomberg-ийн явуулсан судалгааны үр дүнд, Япон улсын бондын зах зээлийн өгөөж бага байгаатай холбоотойгоор бүс нутгуудын арилжааны банкууд өгөөж эрэлхийлэн эрсдэлтэй хөрөнгө оруулалтууд хийж мөн эзэмшиж буй ЗГҮЦ-ны хэмжээгээ бууруулж байгаа гэсэн дүгнэлт гарсан байна.

**БНХАУ:** БНХАУ-ын хөрөнгө оруулагчид АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны эхний шатны хэлэлцээр ойрын хугацаанд хийгдэнэ хэмээх хүлээлтээс үүдэн БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд дахин өсөлттэй байлаа.

Мөн, БНХАУ-ын үйлдвэрлэлийн салбар өсөлттэй байна. Үйлдвэрлэлийн компаниудын ашиг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.4%-аар өссөн сүүлийн 8 сарын хамгийн өндөр төвшин юм.

Эх сурвалж: Troweprice.com

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,191.90	1.59% ▲
Dow Jones	АНУ	28,645.26	0.67% ▲
S&P 500	АНУ	3,240.02	0.58% ▲
Nasdaq	АНУ	9,006.62	0.91% ▲
S&P/TSX	Канад	17,168.21	0.29% ▲
FTSE 100	Их Британи	7,644.90	0.82% ▲
S&P/ASX 200	Австрали	6,821.70	0.08% ▲
Nikkei 225	Япон	23,837.72	0.09% ▲
Hang Seng	Хонг Конг	28,225.42	1.27% ▲

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.86
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.52
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.53
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.33
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.03
DBM' 2023	USD	7.250%	106.23
TDBM' 2020	USD	9.375%	101.98
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.45

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.799	0.02 ▲
Libor 3M	1.944	0.01 ▲
Libor 6M	1.921	0.00 ▲
Libor 1YR	2.004	0.00 ▲
US 2YR Bond	1.581	-0.05 ▼
US 3YR Bond	1.601	-0.06 ▼
US 5YR Bond	1.683	-0.04 ▼
US 10YR Bond	1.882	-0.03 ▼

### Валютын ханш /төг/

Валют	2019.12.27	Өөрчлөлт
USD	2,733.53	0.07% ▲
CNY	390.61	0.22% ▲
EUR	3,043.51	0.21% ▲
RUB	44.10	0.71% ▲
KRW	2.35	0.00% ▲
JPY	24.97	-0.04% ▼
CAD	2,085.63	0.33% ▲

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,510.56	1.95% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	17.77	3.31% ▲
Зэс	USD/lb.	282.95	0.84% ▲
Нүүрс	USD/MT	69.25	2.47% ▲
WTI газрын тос	USD/bbl.	61.72	2.12% ▲
Brent газрын тос	USD/bbl.	68.16	3.05% ▲

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. XI	5.2%
Бодлогын хүү	2019. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. XI	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. XI	11.49%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. XI	4.80%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. XI	16.88%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. XI	10.58%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 52 компанийн 1,190.9 сая төгрөгийн 2,674,294 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Дархан гурил тэжээл” /DAR/ компанийн хувьцаа 14.99%-аар буюу хамгийн ихээр өсөж 3,690.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Нако түлш” /NKT/ компанийн хувьцаа 26.00%-аар буурч 37.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 4,600 ширхэг үнэт цаас 466.0 сая төгрөгөөр арилжаалагджээ.

12-р сарын 27-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,646.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,191.90 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.59%-аар өссөн байна.

**MSE Индекс**

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

**Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/**

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

**Зах зээлийн хураангуй**

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,657.0
Зах зээлийн үнэлгээ	2,646,283.0

**Зах зээлийн индекс**

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,191.90	1.59% ▲
MSE I индекс	9,232.24	1.40% ▲
MSE II индекс	7,777.34	-0.38% ▼

**Идэвхтэй арилжигдсан хувьцаа**

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Хөвсгөл алтан дуулга	478,930	311,172,602
Улаанбаатар хивс	20,500	293,150,000
Ард даатгал	169,746	124,731,365
Ард санхүүгийн нэгдэл	68,609	122,748,558
АПУ	162,137	98,332,259

**Өсөлттэй хувьцаа**

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан гурил тэжээл	3,690.00	14.99% ▲
Авто импекс	2,005.00	14.90% ▲
Инвескор ББСБ	2,472.00	13.45% ▲
Ард даатгал	779.00	8.37% ▲
Дархан нэхий	13,980.00	6.64% ▲

**Бууралттай хувьцаа**

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Нако түлш	37.00	-26.00% ▼
Дархан хүнс	2,560.00	-22.42% ▼
Силикат	68.00	-15.00% ▼
Эрдэнэт занда	1,450.00	-14.71% ▼
Улсын их дэлгүүр	1,000.00	-8.26% ▼

**Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд**

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	936,357,775
Бумбат-Алтай	743,894,551
Тулгат чандмань баян	586,466,420
Ард секьюритиз	476,024,242
Голомт капитал	107,566,903

**Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани**

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	619.56	659,324
Таван толгой	6,500.00	342,324
МИК Холдинг	14,040.00	290,759
Говь	259.98	202,814
Инвескор ББСБ	2,472.00	177,311

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	2,300	231,702,000	100,740	100,740	156	15.140%
2	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	2,300	234,347,000	101,890	101,890	156	15.140%

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.12.24-нд олгов
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.12.24-нд олгов
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Хорооны XIX хуралдаан болов

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит XIX хуралдаан болж нийт 25 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар “Бодь даатгал” ХХК-ийн шинээр гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэлээ. Тус компанийг бүртгэснээр Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани нэгээр нэмэгдэв. Өмнө нь “Ард даатгал” ХК, “Мандал даатгал” ХК, “Монгол даатгал” ХК-ууд биржид бүртгэгдэн хөрөнгийн зах зээлд өрсөлдөж байгаа билээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах чиглэлд онцгой анхааран ажиллаж байна. Энэ удаагийн хуралдаанаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд “Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”, “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”, “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт” зэрэг багтлаа.

Хуралдаанаар “Ниямазон аудит” ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэж, “Ти Ди Би капитал ҮЦК” ХХК-д гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах брокер болон номинал дансаар дамжуулж харилцагчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгож, “Эрдэнэт венчур ассет менежемент” ХХК-д үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олголоо.

Мөн зарим даатгалын компанийн даатгалын бүтээгдэхүүн, бүтцийн өөрчлөлт, эрх бүхий албан тушаалтныг бүртгэж, нэр бүхий иргэдэд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож зарим үнэт цаасны компани, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг сунгах, тусгай зөвшөөрөл нэмж олгох, хүчингүй болгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

**Эх сурвалж:** Санхүүгийн Зохицуулах Хороо

### Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Австрали улсын элчин сайдыг хүлээн авч уулзлаа

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Австрали Улсын Элчин сайд Дэйв Воусэн, нэгдүгээр нарийн бичгийн дарга Доктор Алекс Стивенс нарыг хүлээн авч уулзан хамтран ажиллах талаар ярилцлаа.

Уулзалтад Хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.Энхбаатар, Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан чиглэлийн ажлын хэсгийнхэн оролцож Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулахын тулд хийж буй ажил, Олон улсын хамтын ажиллагааны бүлэг /ICRG/-тэй тохиролцсон эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөг хэрхэн биелүүлж байгаа талаар танилцуулав.

Австрали Улсын Элчин сайд Дэйв Воусэн, Хороо богино хугацаанд дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгааг онцлон дурдаад Олон улсын хамтын ажиллагааны бүлэгтэй тохиролцсон эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөг биелүүлэхтэй холбоотойгоор дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжтойгоо илэрхийллээ.

**Эх сурвалж:** Санхүүгийн Зохицуулах Хороо

### МХБ-д шинээр хоёр үнэт цаасны компани гишүүнээр элслээ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 10-р сарын 11-ний өдрийн 2019/09, 2019/10 тоот тогтоолоор “Монгол хувьцаа ҮЦК” ХХК болон “Домикс сек ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүнээр элсүүллээ.

“Домикс сек ҮЦК” ХХК болон “Монгол хувьцаа ҮЦК” ХХК-ууд нь үнэт цаасны зах зээлд брокерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй бөгөөд тус хоёр компани гишүүнээр элссэнээр МХБ-ийн гишүүн компанийн тоо 53-д хүрлээ.

**Эх сурвалж:** Монголын Хөрөнгийн Бирж

### “Улаанбаатар хивс” ХК-ийн багцын арилжаа явагдлаа

2019 оны 12-р сарын 24-ний өдөр багцын арилжаагаар “Улаанбаатар Хивс” ХК-ийн 20,500 ширхэг үнэт цаас 293,150,000 төгрөгөөр буюу нэгж хувьцааны үнэ нь хамгийн сүүлийн хаалтын ханшаас 10.9%-аар доогуур үнээр арилжаалагдсан байна.

**Эх сурвалж:** Ти Ди Би Капитал ҮЦК

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Эрдэнэс Монгол” ХХК Монголбанктай үнэт металл худалдах, худалдан авах гэрээг байгууллаа

“Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК Монголбанктай үнэт металл худалдах, худалдан авах хамтын ажиллагааны гэрээг байгуулж, Салхитын мөнгөний ордоос олборлож, цэвэршүүлсэн мөнгөний дээжийг Эрдэнэсийн санд тушаалаа. Таван жилийн хугацаатай энэхүү гэрээний хүрээнд 850-980 хувиас доошгүй сорьцтой алт, мөнгө болох үнэт металлын агууламж бүхий гулдмайг “Эрдэнэс Силвер Ресурс” компани Монголбанкд нийлүүлж, улмаар гэрээнд тусгасны дагуу төлбөр авах юм.

Гэрээнд гарын үсэг зурах ёслолд УИХ-ын дарга Г.Занданшатар, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нар оролцож, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Мөнхбаяр болон Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар үнэт металл худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зурлаа.

Энэ үеэр УИХ-ын дарга Г.Занданшатар “Өнөөдөр бид түүхэн үйл явдлын гэрч боллоо. Салхитын мөнгөний орд стратегийн том орд биш. Энэ орд хэсэг бүлэг хүний хууль бус үйл ажиллагааны золиос болж байсан бол өнөөдөр дээжийг нь Монголбанкны Эрдэнэсийн санд тушааж байна. Монгол Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд Салхитын мөнгөний ордын үйл ажиллагаа эерэгээр нөлөөлнө гэж найдаж байна. “Эрдэнэс Монгол” компани, Монголбанктай дөнгөж сая таван жилийн гэрээ байгууллаа. Үндэсний баялгийн сан байгуулах том эхлэлийг энэ гэрээгээр тавьж байна. 2019 он өөрчлөлт шинэчлэлтийн жил байсан. Дараа жил бид ирэх онуудын хөгжлийн суурийг тавина. Үндсэн хуулийн 6.1-т “Газар, газрын хэвлий, ой, усны нөөц ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна” гэж заасан. Энэ баялгийг урт хугацааны бодлогод үндэслэн, үр өгөөжтэй ашиглана. Орлогыг Үндэсний баялгийн санд төвлөрүүлнэ. Ингэснээр иргэдэд тэгш хүртээмжтэй хуваарилах зарчмыг бид Үндсэн хуульд оруулсан. Энэ зарчим бодитоор хэрэгжиж байгаад би их баяртай байна. Норвеги гэх мэт өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг бид нэвтрүүлж чадлаа. Салхитын мөнгөний ордын нөөц бага боловч ач холбогдол нь их. Цаашид Хөгжлийн банк алт, мөнгөө барьцаалан бонд гаргах бололцоотой” гэлээ.

“Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Т.Мөнхбаяр “Компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсны дагуу таван жилийн хугацаанд 750 тонн мөнгө олборлож, цэвэршүүлж Монголбанкинд тушаах зорилготой ажиллаж байна. Эхний жилд 25-30 тонн мөнгө цэвэршүүлэхээр төлөвлөсөн. Богино хугацаанд технологийн болон үйлдвэрлэлийн туршилтад орж, 500 кг мөнгийг цэвэршүүлэн авсан. Өнөөдөр ийнхүү дээжээ Монголбанкны Эрдэнэсийн санд тушааж байна. Үйлдвэр ирэх оны зургадугаар сараас бүрэн хүчин чадлаараа ажиллана” гэв.

**Эх сурвалж:** “Эрдэнэс Монгол” ХХК

### БНХАУ XI сард Монголоос 2.76 сая тонн, Австралиас 2.56 сая тонн коксжих нүүрс импортолжээ

Өнгөрсөн сард БНХАУ-ын коксжих нүүрсний импортын 45 орчим хувийг Монгол Улс нийлүүлсэн бол Австрали улс 41 хувийг бүрдүүлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Австралийн коксжих нүүрсний нийлүүлэлт 11 хувиар буурсан бол Монголынх 45 хувиар өссөн байна. 11 дүгээр сарын байдлаар БНХАУ Монголоос 2.76 сая тонн коксжих нүүрс, Австралиас 2.56 сая тонн коксжих нүүрс импортолсон талаар БНХАУ-ын гаалийн мэдээлэлд дурдлаа. Бусад улсыг харвал ОХУ-ын коксжих нүүрсний нийлүүлэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.3 дахин нэмэгдэж, 544 мянга шахам тонн болсон байна.

**Эх сурвалж:** BloombergTV.mn

### НМХГ: XII сард үйлдвэрлэсэн шахмал түлшний дээжийг лабораторид өгсөн

Даваа гарагаас хойш угаарын хийд хүнд болон хөнгөн хэлбэрээр хордсон гэх шалтгаанаар зургаан өрхийн иргэн эмнэлгийн тусламж авсан байна.

Одоогоор эмнэлэгт гурван том хүн, нэг хүүхэд хэвтэн эмчлүүлж байгааг Нийслэлийн онцгой байдлын газар мэдээллээ. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар “Тавантолгой түлш” ХХК-д байнгын хяналт тавин ажиллаж байгаагаа онцоллоо. XI сард үйлдвэрлэсэн сайжруулсан нүүрс стандартын шаардлага хангасан гэж мэдээлсэн. XII сард үйлдвэрлэсэн түлшний дээжийг лабораторид өгсөн байгаа аж.

**Эх сурвалж:** BloombergTV.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.